


утас: 99000504



**ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ
ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2012 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 4/83

Улаанбаатар хот

**Техникийн нөхцөл олгох, холболт хийхэд
мөрдөх журам батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 108 дугаар тогтоол, Эрдэс баялаг эрчим хүчний сайдын 2010 оны 127 дугаар тогтоолоор баталсан "Нэгдсэн сүлжээний дүрэм"-ийн 4.1.1 заалт; "Холболтын заавар батлах тухай", Эрчим хүчний зохицуулах газрын Зохицуулагчдын зөвлөлийн 2002 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 70 дугаар тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2012 оны 05 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн нөхцөл олгох, холболт хийхэд мөрдөх журмыг нэгдүгээр хавсралтын ёсоор, Техникийн нөхцлийн тодруулах хуудсыг хоёрдугаар хавсралтын ёсоор, Техникийн нөхцөл олгох загварыг гуравдугаар хавсралтын ёсоор, Дамжуулах сүлжээнд шинэ хэрэглэгчдийг холбох тухай зөвшөөрлийн хуудсыг дөрөвдүгээр хавсралтын ёсоор, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн техникийн нөхцөл олгох комиссыг тавдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Техникийн нөхцөл олгох, холболт хийх журмыг алба, салбар, нэгжүүдийн удирдлагуудад танилцуулан компанийн хэмжээнд 2012 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Ерөнхий инженер Д.Чинбатад үүрэг болгосугай.

3. Техникийн нөхцөл олгоход хэрэглэгчээс авах хураамжийг төвлөрүүлэх, орлого, зарлагын тооцоонд хяналт тавьж ажиллахыг Эдийн засаг, Санхүүгийн хэлтсийн дарга Ц.Өлзийжаргалд даалгасугай.

4. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналтын хэлтсийн дарга Я.Мөнхтөрд үүрэг болгосугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Техникийн нөхцөл олгох, холболт хийхэд мөрдөх журам батлах тухай Гүйцэтгэх захирлын 2011 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/49 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.ТҮВШИНЧУЛУУН

My Documents\my doc\lalan bichig 2012\Tushaal\07.06 tbb.doc.

21706000075

ЦДҮС ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын
2012 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн
1/3 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



Техникийн нөхцөл олгох, холболт хийхэд мөрдөх журам

Нэг. Нийтлэг үндэслэл.

- 1.1 Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн эзэмшлийн шугам сүлжээнд иргэн, хуулийн этгээдийн цахилгаан тоног төхөөрөмжийг шинээр угсрах болон, шинэчлэн өргөтгөж холбоход зориулж техникийн нөхцөл олгох, сонгох, нөхөн олгоход энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2 Иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгох, сонгох, нөхөн олгоход Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний зохицуулах газраас баталсан "холболтын заавар", Аж ахуйн харилцааны дүрэм, Цахилгаан байгууламжийн дүрэм, Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм, Эрчим хүчний үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагуудад даган мөрдөх галын аюулгүйн дүрэм, цахилгаан техникийн байгууламжийн угсралтын норм ба дүрмүүдийг үндэс болгоно.
- 1.3 Энэхүү журмыг цахилгаан эрчим хүчээр хангагч ЦДҮС ТӨХК болон цахилгаан эрчим хүчээр хангуулагч иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

Хоёр. Журмын нэр томъёо

- 2.1 Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно
 - 2.1.1 Цахилгаан техникийн байгууламж гэж – Цахилгаан машин, цахилгаан аппарат, трансформатораар цахилгаан энергийг дамжуулах, хуваарилах, хувирган ашиглах замаар үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж, цахилгааны хэрэглээ хангах зориулалттай иж бүрдмэл цахилгаан тоног төхөөрөмжийг;
 - 2.1.2 Техникийн нөхцөл гэж-цахилгаан техникийн байгууламжийг шинээр угсрах, өргөтгөн шинэчилж цахилгаан дамжуулах сүлжээнд холбохын тулд иргэн, хуулийн этгээд заавал биелүүлэх ёстой техникийн иж бүрдмэл шаардлагыг илэрхийлсэн албан ёсны бичгэн шийдвэрийг;
 - 2.1.3 Тодруулах хуудас гэж –техникийн нөхцөл олгохыг хүссэн иргэн, хуулийн этгээдийн шинээр угсрах, өргөтгөн шинэчлэх цахилгаан техникийн

байгууламжийн техникийн үзүүлэлтийн тухай албан ёсны тодруулсан мэдэгдлийг;

- 2.1.4 Техникийн нөхцлийг авахад төлөх үйлчилгээний хураамж гэж – Дамжуулах шугам сүлжээнээс цахилгаан хангамжийн тэжээл авахаар хүсолт гаргасан иргэн, хуулийн этгээдийн шинээр барих, өргөтгөн шинэчлэх, цахилгаан техникийн байгууламжийн тоног төхөөрөмжийн хүчин чадал, хүчдлийн ангилал, хэрэглэгчийн зэрэглэл, хэрэглэгч нь дамжуулах шугам сүлжээнээс орших зайн хэмжээ, цаг уурын нөхцөл зэрэг үзүүлэлтүүдийн хамаарал нь дамжуулах шугам сүлжээний техникийн найдвартай ажиллагааны горимд нөлөөлөх техник-эдийн засгийн судалгаа, тооцоо хийж дүгнэлт гаргах үйлчилгээнд зарцуулагдах ажлын хөлсийг;

Гурав. Техникийн нөхцөл олгоход бүрдүүлэх материал

- 3.1 Техникийн нөхцөл авахыг хүсэгч иргэн, хуулийн этгээд дараах бичиг баримтыг заавал бүрдүүлнэ.
- 3.1.1 Техникийн нөхцөл олгож өгөхийг хүссэн өргөдөл, албан бичиг
- 3.1.2 Тухайн цахилгаан техникийн байгууламжийг шинээр барих, өргөтгөн шинэчлэх газрын байршлын зураг, газар эзэмших эрх олгосон зөвшөөрлийн тухай, нийслэл хот, орон нутгийн засаг даргын захирамжийн хуулбар
- 3.1.3 Төвийн бүсийн цахилгаан дамжуулах төрийн өмчит хувьцаат компаниас олгосон техникийн нөхцлийн тодруулах хуудсыг үнэн зөв тодотгосон мэдэгдэл ,

Дөрөв. Техникийн нөхцөл олгоход баримтлах үндсэн чиглэл

- 4.1 Техникийн нөхцлийг энэхүү журмын 5 дугаар хавсралтаар баталсан комисс боловсруулж, нэгдсэн дүгнэлт, техникийн шийдэл гаргасны дараа компанийн Гүйцэтгэх захирал хянан баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 4.2. Техникийн нөхцөл олгох комисс нь дор дурьдсан чиглэл баримталж ажиллана.
- 4.2.1. Техникийн нөхцөл авахыг хүсэгч иргэн, хуулийн этгээдээс (захиалагч) энэхүү журмын гуравдугаар бүлэгт заасан техникийн нөхцөл олгоход бүрдүүлэх материалыг бүрэн бүрдүүлэн авч хянаана.
- 4.2.2 Техникийн нөхцөл олгохдоо Монгол Улсын Эрчим Хүчний Нэгдсэн Систем хөтөлбөр, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн чиг баримтлал, эх үүсвэрийн техникийн боломж, дамжуулах шугам сүлжээний нэвтрүүлэх

чадвар, тогтвортой ажиллагааны горим, энэхүү журмын нэгдүгээр бүлгийн 1.2-т заасан эрхийн акт, дүрэм журмуудыг үндэс болгон мөрдөж ажиллана

- 4.2.3 Энэхүү журмын гуравдугаар бүлэгт заасан техникийн нөхцөл олгоход бүрдүүлэх материалыг бүрэн гүйцэд хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногт багтаан техникийн нөхцөл олгох, эс олгох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, захиалагчдад хариу мэдэгдэнэ.
- 4.2.4 Энэхүү комисс нь компанийн хэмжээнд техникийн нөхцөл олгох ажлыг хариуцах бөгөөд захиалагч орон нутгийн салбарын ашиглалтын дэд станц, шугамаас холбогдохоор техникийн нөхцөл авах хүсэлт гаргавал, тухайн салбарын удирдлагаас албан ёсоор санал авч компанийн хэмжээний нэгдсэн техникийн бодлоготой уялдуулан шийдвэрлэнэ.
- 4.2.5 Техникийн нөхцөл олгох комиссын нарийн бичгийн дарга нь захиалагчаас ирүүлсэн өргөдөл, албан бичигт удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу ажиллах бөгөөд анхан шатны материалыг бүрэн гүйцэд бүрдүүлэн хянаж авах, тухайн захиалагчийн цахилгаан техникийн байгууламжийн цахилгаан тоног төхөөрөмжийг дамжуулах сүлжээнд холбож болох дэд станц, шугамын холболтын цэгийг газар дээр нь биечлэн үзэж зураг схем гаргах, техникийн нөхцлийн анхан шатны боловсруулалт хийж, ашиглалтын албад, холбогдох салбараас санал авч нэгтгэн эцэслэн боловсруулж комиссын хуралд оруулж шийдвэрлүүлэх технологи ажлуудыг хариуцан гүйцэтгэнэ.
- 4.3 Хоорондоо ойролцоо байршилтай хэд хэдэн хэрэглэгч (захиалагч) дамжуулах шугам сүлжээнд холбогдох техникийн нөхцөл хүссэн тохиолдолд дамжуулах сүлжээний техникийн боломжийг харгалзан техникийн нөхцөл олгогч эдгээр хэрэглэгчидтэй урьдчилан тохиролцсоны үндсэн дээр толгой хэрэглэгчийн цахилгаан техникийн байгууламжаас бусад хэрэглэгчдийг дамжуулан тэжээх техникийн нөхцлийг холбогдох цэгүүдийг тодорхой зааж тус тусад нь олгоно.
- 4.4 Хэрэглэгчдэд техникийн нөхцлийг энэхүү журмын гуравдугаар хавсралтанд заасан загвараар олгох бөгөөд гүйцэтгэх ажлын хэмжээнээс хамааруулан 2 жилийн хугацаатай олгоно. Хэрэв хэрэглэгч энэ хугацаанд цахилгаан техникийн байгууламжийн угсралт монтажийн ажил эхлээгүй бол техникийн нөхцлийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө техникийн нөхцөл олгогч дээр ирж 1 жилийн

хугацаатай сунгуулж болно. Хэрэв хэрэглэгч техникийн нөхцлөө үрэгдүүлсэн бол 1 жилийн хугацаатай нөхөн олгуулж болно.

- 4.5 Техникийн нөхцлийг 3 хувь үйлдэж техникийн бодлогын хэлтэс, архив, захиалагчид өгөх бөгөөд шаардлагатай бол ашиглалтын албад, холбогдох салбар хувилан авч болно.

Тав. Техникийн нөхцөл олгох үйлчилгээний төлбөр

- 5.1 Иргэн хуулийн этгээд дамжуулах шугам сүлжээнд холбогдохоор техникийн нөхцөл авахдаа хүчдлийн ангиллаас хамаарч нэг объектонд дор дурдсан үйлчилгээний хураамжийг төлнө.

• 6-10 кВ-н сүлжээнд холбогдох бол	100 000 төгрөг
• 35 кВ-ын сүлжээнд холбогдох бол	200 000 төгрөг
• 110 кВ-н сүлжээнд холбогдох бол	300 000 төгрөг
• 220 кВ ба түүнээс дээш сүлжээнд холбогдох бол	400 000 төгрөг

- 5.2 Энэхүү хураамжинд техникийн нөхцөл авагч иргэн, хуулийн этгээдийн цахилгаан тоноглолыг дамжуулах сүлжээнд холбох цэгт тухайн захиалагчдад зориулан хийгдэх шинээр суурилагдах, өргөтгөх, солих тоног төхөөрөмжийн үнэ, түүний угсралтын зардал орохгүй.

Зургаа. Эзэмшлийн зааг тогтоох

- 6.1 Дамжуулах шугам сүлжээ, хэрэглэгчийн шинээр угсарсан, өргөтгөсөн цахилгаан тоног төхөөрөмжийн эзэмшлийн заагийг холболтын цэгээр зааглан тогтооно.

Долоо. Ашиглалт явуулах хувилбар

- 7.1 Хэрэглэгчийн эзэмшлийн шинээр угсарсан өргөтгөсөн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалтыг дор дурьдсан хувилбараар явуулж болно.

7.1.1 Хэрэглэгч (захиалагч) өөрөө хариуцан техникийн үйлчилгээ, ашиглалт явуулах.

7.1.2 Хэрэглэгч (захиалагч) Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ төрийн өмчит Хувьцаат компанитай ашиглалт явуулах гэрээ хийх.

7.1.3 Хэрэглэгч (захиалагч) өөрийн эзэмшлийн шинээр угсарсан, өргөтгөсөн тоног төхөөрөмжөө балансын үнээр, үнэ төлбөргүйгээр дамжуулах шугам сүлжээ төрийн өмчит хувьцаат компанид шилжүүлэх

- 7.2 Техникийн нөхцөл олгох үед талууд ашиглалт, эзэмшлийн заагаа харилцан тохиролцож болно.

**найм. Дамжуулах шугам сүлжээнд хэрэглэгчийн объектыг
холбох ажиллагаа**

- 8.1 Хэрэглэгчийн эзэмшлийн (объектыг) цахилгаан тоног төхөөрөмжийг дамжуулах шугам сүлжээнд холбож ашиглалтанд оруулах ажиллагааг цахилгаан техникийн байгууламжийн угсралтын норм ба дүрэм, Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах дүрэм - 2009-д заасныг удирдлага болгон мөрдөнө.

Ес. Техникийн нөхцөл олгох боломжгүй тохиолдол

- 9.1 Техникийн бодит шалтгаанаас болж дор дурьдсан тохиолдолд техникийн нөхцөл олгох боломжгүй.
- 9.1.1 Эх үүсвэрийн дутагдалтай.
 - 9.1.2 Дамжуулах шугам сүлжээний нэвтрүүлэх чадвар хүрэлцэхгүй.
 - 9.1.3 Дамжуулах шугам сүлжээний тогтвортой ажиллагааны горим алдагдуулах.
 - 9.1.4 Дамжуулах шугам сүлжээний реле хамгаалалт, автоматикийн селектив ажиллагааг алдагдуулах.
 - 9.1.5 Систем үүсгэгч цахилгаан дамжуулах шугамаас.
 - 9.1.6 Импорт, экспортын цахилгаан дамжуулах шугамаас.
 - 9.1.7 Нэгдүгээр зэрэглэлийн онцгой хэрэглэгчийн цахилгаан дамжуулах шугамаас.
 - 9.1.8 Хэрэглэгч (захиалагч) техникийн нөхцөл авах материалаа дутуу бүрдүүлсэн болон худал мэдүүлэг өгсөн.

ЦДҮС ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын
2012 оны 2-дугаар сарын 26-ны өдрийн
1/83 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ТЕХНИКИЙН НӨХЦЛИЙН ТОДРУУЛАХ ХУУДАС

20.. он ... сар өдөр

№

.....ХОТ

1. Хэрэглэгчийн нэр, хаяг, утас,.....
 2. Угсралтын ажлын эхлэх дуусах хугацаа
.....
 3. Хүчин чадлыг бүрэн эзэмших хугацаа
 4. Суурилагдсан хүчин чадал (кВт)
 5. Тооцооны чадал (кВт)
 6. Чадлын коэффициент
 7. Хэрэглэгчийн ажлын горим
 8. Зэрэглэл
 9. Шинээр баригдах объект, тэжээл авах шугам станцын хоорондох зай
 10. Цахилгаан эрчим хүчний тооцоо хийх хэлбэр
 11. Цаашид өргөтгөгдөх бол эхлэх дуусах хугацаа, хүчин чадал
.....
 12. Орон нутгийн засаг захиргааны газар олголтын тогтоолын дугаар, огноо
.....
- Тодруулга мэдэгдлийг гаргасан
хэрэглэгчийн:..... /нэр, албан тушаал/

ЦДҮС ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын
2012 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн
А/83 дугаар тушаалын 3 дугаар хавсралт



БАТЛАВ.
ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Э.ТҮВШИНЧУЛУУН

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ ЗАГВАР

Техникийн нөхцөл хүссэн иргэн, хуулийн этгээдийн

Нэр:.....
Хаяг:.....
Байршил:.....

Үйлдвэр үйлчилгээний зориулалт:.....

Шинээр суурилуулах хүчин чадал:..... МВт

Техникийн нөхцөл олгосон үндэслэл:.....

Иргэн, хуулийн этгээдээс техникийн нөхцөл авах хүсэлт гаргасан материалд тодорхойлсон шинээр суурилагдах, шинэчлэн өргөтгөх, хүчин чадлаар хангах, дамжуулах шугам сүлжээний техникийн боломжийг судлан тооцож үзсний үндсэн дээр тухайн иргэн, хуулийн этгээдэд дор дурьдсан техникийн нөхцөл олгов,

1. Иргэн, хуулийн этгээд өөр дээрээкВ-ын МВт чадалтай фазын ороомогтой, гүн газардуулгын нейтральтай хүчний трансформатор бүхий бууруулах дэд станц шинээр суурилуулан угсарч тоноглох.
2. Дамжуулах шугам сүлжээний дэд станцын 35, 110, 220 кВ-ын ил хуваарилах байгууламжийн..... хэсэгт, эсвэл дугаартайнэртэй 110-220 кВ-н шугамын..... дугаар анкераас, эсвэл завсарын тулгуурыг анкер болгон өөрчилж, эсвэл 6-10 кВ-ын хуваарилах байгууламжийн дугаар секцийн дугаар ячийгийг тус тус өргөтгөл хийж, шинээр 35, 110, 220 кВ-н агаарын шугам, 6-10 кВ-ын агаарын ба кабель шугам татаж хэрэглэгч өөрийн шинээр барих дэд станцыг тэжээх.
3. Шинээр угсран монтажлах шугам, дэд станцын цахилгаан тоног төхөөрөмжүүдийг Монгол улсын цаг уурын нөхцөлд нийцсэн, Монгол улсын болон олон улсын техникийн стандарт шаардлага хангасан тоног төхөөрөмжийг сонгох.
4. Дамжуулах шугам сүлжээнд холбогдох тоног төхөөрөмж нь заводод үйлдвэрлэсэн, угсрах, тээвэрлэх, ашиглах зэрэг зааваруудыг багтаасан техникийн иж бүрдэл бичиг баримттай байна.
5. Иргэн хуулийн этгээдийн шинээр угсрах монтажлах барилга, байгууламжийн зураг төсөл, угсралт монтажийн ажлыг гүйцэтгэгч нь дамжуулах шугам сүлжээний цахилгаан тоног төхөөрөмжинд зураг төсөв, угсралт монтаж хийх эрхтэй байх бөгөөд зураг төсөл хийхдээ нийслэл хот, аймгийн архитектур төлөвлөлтийн газар, инженерийн байгууламжийн ашиглалтын байгууллагууд, галын аюулаас сэргийлэх байгууллага, эрүүл ахуйн болон байгаль орчныг хамгаалах байгууллагатай зөвшилцөж хийнэ.
6. Шинээр барих, угсрах барилга байгууламжийн угсралт монтажийн ажил эхлэхээс өмнө

түүний зураг төсөл, экспиртизийн дүгнэлтийн хамт техникийн нөхцөл олгогчид заавал хянуулна.

7. Зураг төсөл болон угсралт монтажийн гүйцэтгэгч байгууллага нь техникийн нөхцөл, "Цахилгаан байгууламжийн дүрэм БД43-101-03", Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм, Цахилгаан техникийн байгууламжийн угсралтын норм ба дүрэм техникийн стандарт шаардлагуудыг даган мөрдөж ажиллана.
8. Шинээр угсрах, монтажлах цахилгаан тоног төхөөрөмжийн газар шорооны ажил болон газардуулгын байгууламжийн газар шорооны ажил хийж тор электрод суурилуулж гагнах үед дамжуулах компанийн төлөөлөгч заавал байлцуулан гүйцэтгэж, далд ажлын акт үйлднэ.
9. Дамжуулах сүлжээнд шинээр холбогдох объектын холболтын цэгүүд болон хэрэглэгчийн оролтонд хэмжүүрийн трансформатор бүхий сэлгэн залгалтын аппарат угсарч, цахилгаан энерги хэмжих 0,5-н нарийвчлалтай электрон буюу түүнтэй адилтгах, Монгол улсын стандартад зөвшөөрөгдсөн, баталгаат тоолуур суурилуулна.
10. Цахилгаан техникийн байгууламжийн цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт, монтажийн ажил бүрэн дуусч, хүчдэлд залгаж уг объектын ажиглалт, эзэмшлийн зааг тодорхой болсны дараа цахилгаан энергийн тооцоог дамжуулах, түгээх сүлжээ компанийн алинтай нь хийхийг шийдвэрлэнэ.
11. Энэхүү техникийн нөхцөл нь олгогдсон өдрөөс эхлэн **2 жилийн** хугацаанд хүчинтэй байна.

Комиссын дарга:

Компаний ерөнхий инженер

Нарийн бичгийн дарга:

Техникийн нөхцөл хариуцсан инженер

Комиссын гишүүд:

Техник бодлогын хэлтсийн дарга

Диспетчер зохицуулалтын хэлтсийн дарга

Холбогдох салбаруудын Ерөнхий инженерүүд

ЦДҮС ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын
2012 оны 4 дугаар сарын 16-ны өдрийн
4/83 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт



**Дамжуулах сүлжээнд шинэ хэрэглэгчдийг холбох тухай
зөвшөөрлийн хуудас №**

20... он сар өдөр

1. Хэрэглэгчийн нэр:
ТЗЭ-нь Хэрэглэгч нь
2. Олгогдсон техникийн нөхцлийн дугаар, огноо
3. ЦЭХ дамжуулах гэрээний дугаар, огноо
4. Хэрэглэгчийн тоног төхөөрөмж холбогдож байгаа дамжуулах сүлжээний дэд станц, шугам, хуваарилах байгууламжийн нэр:.....
5. Хэрэглэгчийг холбосон ячийкийн дугаар, нэр:
6. Хэрэглэгчийг холбосон агаарын болон кабель шугамын техникийн үзүүлэлт /марк тип, хөндлөн огтлол, урт/
.....
7. Суурилуулсан тоног төхөөрөмжийн өгөгдлүүд:
..... Тоолуурын марк, заводын дугаар
..... Тоолуур баталгаажуулсан огноо
..... Холболт хийх үеийн заалт
..... Суурилуулсан байршил
..... Гүйдлийн трансформаторын марк, заводын дугаар
..... Гүйдлийн трансформаторын коэффициент
..... Хүчдлийн трансформаторын марк, №
8. Тоолуурын битүүмжийн тухай тэмдэглэл
9. Хэрэглэгчийг холбох үеийн ашиглалт үйлчилгээний зааг, схем

10. Хүчдэлд залгуулахын өмнөх тоног төхөөрөмжийн бэлэн байдлын нотолгоо:

- Техникийн бодлогын хэлтсийн даргаон сар өдөр
..... Салбарын ашиглалтын албаны даргаон сар өдөр
..... Салбарын РХХТ албаны даргаон сар өдөр
Хүчдэлд залгах захиалга авсан:
..... Диспетчер зохицуулалтын хэлтсийн даргаон сар өдөр

Залгахыг зөвшөөрсөн:.....Ерөнхий инженер он ... сар ... өдөр

Зөвшөөрлийн хуудас бичсэн: ТБХ-ийн шинэчлэлтийн инженер
Уг зөвшөөрлийн дагуу залгалт (таслалт)-ын 20... оны-р сарын-ны өдрийн
.....цаг минутанд гүйцэтгэв.

Диспетчер инженер...../ /

ЦДҮС ТӨХИГ-ийн гүйцэтгэх захирлын
2012 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн
03 дугаар тушаалын 5 дугаар хавсралт



ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ КОМИСС

Комиссын дарга:

Компаний ерөнхий инженер

Нарийн бичгийн дарга:

Техникийн нөхцөл хариуцсан инженер

Комиссын гишүүд:

Техник бодлогын хэлтсийн дарга

Диспетчер зохицуулалтын хэлтсийн дарга

Холбогдох салбаруудын Ерөнхий инженерүүд

Хянасан: Ерөнхий инженер Д.Чинбат

Боловсруулсан:.....Техникийн нөхцөл хариуцсан
инженер И.Мянганбаяр